



**УЛСЫН БУРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

*Даргын оны ал сарын № едөр*

*Дугаар 67188*

Уланбаатар хот

О.Оюунгэрэлд сахилгын  
шийтгэл ногдуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын буртгэлийн өрөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”ын 1.5.2, 3.5.2 дахь хэсэг, Улсын буртгэлийн өрөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын буртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”ын 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийспэллийн Хан-Уул дуургийн Улсын буртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын буртгэлийн тасгийн буртгэгч Оросын Оюунгэрэл нь хуулиар хулээсэн үргээ биелүүлээгүй, эрхэлсэн ажилдаа хайнга хандсан болох нь 2023 оны 579, 704 дугаартай хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын буртгэгч О.Оюунгэрэлд үүрэг болгосугай.

3. Албан хаагчадад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хан-Уул дуургийн Улсын буртгэлийн хэлтэс /С.Оюун-Эрдэнэ/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.



ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

- 142300449